



ШАР ЦАВ, ХҮРДЭТ АГУЙН СОЁЛЫН ӨВИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ШУА-ИЙН ПАЛЕОНТОЛОГИ, ГЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН, ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН, ХАМТАРСАН “ҮЛЭГ ГҮРВЭЛИЙН
МӨРНӨӨС ЦАЙНЫ ЗАМ ХҮРТЛЭХ” СОЁЛЫН ӨВИЙН БАГ

Х.Цогтбаатар, С.Чулуун, Д.Гэрэлтөв, **Б.Майнбаяр**, Ё.Бадрал, Г.Бямбарагчаа



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН



МОНГОЛЫН ПАЛЕОНТОЛОГИЙН
ОЛДВОРЫГ
ХАМГААЛАХ НИЙГЭМЛЭГ ТББ



САНХҮҮЖҮҮЛЭГЧ: “ОЮУ ТОЛГОЙ” ХХК-ИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ
ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН
ЗАХИАЛАГЧ: ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ: “МОНГОЛЫН ПАЛЕОНТОЛОГИЙН ОЛДВОРЫГ
ХАМГААЛАХ НИЙГЭМЛЭГ” ТББ

ШУА-ИЙН ПАЛЕОНТОЛОГИ, ГЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН, ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН,
МОНГОЛИА КҮЭСТ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨЛӨӨЛӨЛ ХАМТАРСАН “ҮЛЭГ ГҮРВЭЛИЙН
МӨРНӨӨС ЦАЙНЫ ЗАМ ХҮРТЛЭХ” СОЁЛЫН ӨВИЙН БАГ

Агуулга

- Төслийн үндэслэл
- Төслийн талбайн тодорхойлолт
- Төслийн үр дүн, ач холбогдол
- Төслийн явцын одоогийн үр дүн
 - Төслийг хэрэгжүүлэхээс өмнө хийгдсэн ажлууд
- Хөрөнгө оруулалтын чиглэл
- Төслөөс хүлээгдэж буй үр дүн





ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 131

Даланзадгад

Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “з” заалт, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Өмнөговь аймгийн Шар цав, Хүрдэт агуйн соёлын өвийн менежментийн төлөвлөгөө”-г хавсралт ёсоор баталсугай.
2. Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг тухайн оны төсөвт тусган хэрэгжүүлж, үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд жил бүр тайлагнахыг аймгийн Засаг дарга /Б.Бадраа/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.БАТЧУЛУУН

П

толгой ХХК-ийн
юги, геологийн
ичлалын
элдэхүүнтэй "Үлэг
ин баг 2015-2025
амгаалах
эн дээр үндэслэн
ний

ны 9 сарын 24-ны
г баталж,
гөсөвт тусган

и бөгөөд 2016-
эсгалыг сэргээх,
байгуулалтын
уулав.

- Өмнөговь а
санхүүжилт
хүрээлэн, Т
компанийн
гүрвэлийн н
он хүртлэх
менежмент
орон нутгий
оролцоотой
- Өмнөговь а
131 тоот то
хэрэгжүүлэ
хэрэгжүүлэ
- Төлөвлөгөө
2017 онд Ц
бэхжүүлэх,
эхний ээлж

Төслийн талбайн тодорхойлолт

- **Шар цавын дурсгалт газрын товч танилцуулга:** Тус палеонтологийн дурсгалт газар нь Өмнөговь аймгийн Манлай сумын Өгөөмөр багийн нутагт харъяалагддаг бөгөөд Ханбогд сумаас зүүн хойш 80 км-т оршдог. Шар цавын үлэг гүрвэлийн мөр бүхий олдворт газрыг Ханбогд сумын нутагт орших Байшин цав олдворт газраас зүүн хойш 10 км-т 1995 оны 7-р сарын 31-ны өдөр Монгол–Японы палеонтологийн хамтарсан экспедиц анх нээсэн. 1996, 2001, 2010, 2015, 2016, 2017 онуудад тус экспедицийн хээрийн анги нарийвчилсан судалгааг явуулсан.

Судалгааны явцад олдворт газраас наандаж 4-5 өөр төрлийн үлэг гүрвэлийн 6-70 см урттай 18000 гаруй мөрийг нээн тогтоосон бөгөөд уг мөрүүд нь байгалийн хэв, ор мөр маягаар хатуу элсжингийн үе давхаргад хадгалагдан үлджээ. Шар цавын олдворт газрыг 2013 оны МУ-ын ЗГ-ын 414 тоот тогтоолоор Өмнөговь аймгийн Манлай сумын нутагт байх Үлэг гүрвэлийн мөр бүхий дурсгалт газар, хамгаалалтын бүсийг тогтоож талбайн хэмжээг 408 га байхаар батласан ба 2014 онд ЮНЕСКО-гийн “Байгалийн өвийн урьдчилсан жагсаалтанд” бүртгүүлээд байгаа нь тухайн дурсгалын ач холбогдол, ирээдүйг бүрэн тодорхойлж байна.

- **Хүрдэт агуйн товч танилцуулга:** 18-20-р зууны эхэн үе хүртэлх хугацаанд Хятадаас Монгол орноор дамжин Орос улс руу гарч байсан худалдааны замын түүхтэй холбогдоно. Тус агуйд нийт судалгаагаар 32 бүлэг Хятад бичээс, нэг бүлэг монгол бичээс, нэг бүлэг Төвд бичээсийг бүртгэсэн.

Энэхүү агуйд хадгалагдан буй хуучин бичээсүүд дотор их төлөв худалдаа хийсэн элч нар замдаа амарч, өөрсдийн сэтгэгдлээ үлдээж орчин тойрны байгаль газар усны тухай тэмдэглэн үлдээхээс гадна Монгол язгууртны бичсэн зүйл нилээд байна. Бичээсүүдийн агуулгыг үзвэл элч нарын тэмдэглэл худалдаачдын ашиг хонжоо, олзны тухай эхнэр, гэр орон эх нутгаа санаж байгаа байдлыг тусгасан бичээсүүд буй. Харин Монгол бичгээр бичсэн хэсгийг бүтнээр нь арилгасан тул түүнд ямар утга агуулга бүхий зүйлийг бичсэнийг тодорхойлж чадахааргүй болсон байна.


Төслийн үр дүн, ач холбогдол

- Энэ бүс нутагт тархсан олдворт газруудаас үлэг гүрвэлийн хөгжлийн хамгийн сонирхол татахуйц, ээдрээтэй, өвөг удмын холбооны хувьд эртний шинж байдлыг хадгалсан амьтдын олдвор олддог учраас сээр нуруутны хувьсал, хөгжлийн зүй тогтлыг танин мэдэх чиглэлийн судалгаанд Монголд төдийгүй олон улсад ихээхэн ач холбогдолтой. Иймд энэ чиглэлийн судалгааг гадна дотны эрдэмтэн судлаач нартай хамтран явуулснаар Монгол орны ховор чухал олдворуудыг олон улсад таниулах сурталчилах ач холбогдолтой. Хүрдэт агуйн орчимд ч гэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тус бүс нутагт амьдарч буй орон нутгийн иргэд, малчдын уламжлалт онцлог шинж бүхий соёлын биет бүс өвийг уламжлуулан хадгалах, түүний бодит хэрэглээг нэмэгдүүлэх, гадаад дотоодын жуулчдад сурталчлах сайн талтай.
- Шар цав, Хүрдэт агуйн дурсгалт газруудыг түшиглэн судалгаа, аялал жуулчлалын цогцолбор төв байгуулснаар бүс нутгийн эдийн засаг, оршин суугчдын амжиргаанд сайнаар нөлөөлнө. Монгол улсад ирж буй жуулчдын ихэнхи нь говийг үзэх сонирхолтой байдаг тул аялагч, жуулчдын тоо нэмэгдэж бүс нутгийн эдийн засаг, хөгжилд тодорхой хувь нэмрээ оруулна гэж үзэж байна.
- Уг цогцолбор газрыг барьж байгуулснаар үйл ажиллагааг нь байнгын тогтвортой байлгахын тулд боловсон хүчин ажилчдыг бэлдэх, тодорхой тооны байнгын ажлын байр шинээр бий болох ач холбогдолтой.


Хөрөнгө оруулалтын чиглэл

Төслийн нийт санхүүжилт, өртөг

- Шар цав, Хүрдэт агуйн дурсгалыг аялал жуулчлалтай хослуулан хамгаалах төслийн хүрээнд хийгдэх бүтээн байгуулалтын ажлын 2015-2025 онд хийж гүйцэтгэхэд шаардлагатай санхүүжилтийн нийт хэмжээг 1.162.800.000 (нэг тэрбум нэг зуун жаран хоёр сая найман зуун мянган төгрөг) сая төгрөг байхаар тооцсон бөгөөд өнгөрсөн 2016-2017 онд 413 000 000 сая төгрөгийн санхүүжилтийг Шар цав болон Хүрдэт агуйн соёлын өвийн хадгалалт хамгаалалтын ажилд зориулан авч гэрээний дагуу зарцуулалтыг хийж ажлын гүйцэтгэв.



Үлэг гүрвэлийн мөрт газар Шар цав



Current situation of the site (early Feb. 2017)

**Whole work will be done by the end of April
Hill top..Arena
Step for the site.**

Roofed area

Trail for observation ..365 m



Үлэг гүрвэлийн мөрний бөөгнөрөл хэсгийг түшиглэн хамгаалалтын 25X15 барилга



I үе шатны ажлын үр дүнгийн танилцуулга

- Хаяг тайлбарыг шинжлэх ухааны мэдээллийг шингээсэн товч бөгөөд тодорхой байлаар шийдэж англи болон монгол хэлээр хийж байршуулав. Ингэснээр тус төслийн нэгдүгээр үе шатны санхүүжилтийн хүрээнд хийгдэх ажил дуусгавар болж хүлээлгэн өгөх арга хэмжээний ажлыг мөн оны 10-р сарын 22-ны билэгт сайн өдөр хийв. Нээлтийн ажиллагаанд Өмнөговь аймгийн ИТХ-ын дарга Х. Сугар, Өмнөговь аймгийн сумдын ИТХ-ын дарга нар, ШУА-ийн Палеонтологи, геологийн хүрээлэнгийн захирал, доктор Х. Цогтбаатар, БСШУСЯ-ны соёл, урлагийн бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн Б. Даваацэрэн, БОАЖЯ-ны аялал жуулчлалын газрын мэргэжилтэн н. Гэрэлсайхан, ШУА-ийн Геологи, газарзүйн бага чуулганы ЭНБДарга Н. Нарантуяа ШУТСангийн мэргэжилтэн Д. Одончимэг, Өмнөговь аймгийн Манлай сумын Засаг дарга Г. Буянхүү, Ханбогд сумын засаг дарга Б. Дэндэвсамба, Оюу Толгой ХХК-ийн Орон нутгийн харилцааны ерөнхий менежер Ш.Байгалмаа, Санхүү эрхэлсэн захирал [Пол Муллинс](#), Гүний уурхайн төслийн захирал [Марко Пирэс](#), Орон нутгийн харилцааны менежер О.Цэрэннадмид, Орон нутгийн харилцааны ажилтан О. Батзориг, Хэвлэл мэдээллийн ажилтан Б. Батбилэг, Зөвшөөрөл хариуцсан зохицуулагч Н. Ариунаа, “Говийн Оюу Хөгжлийн Дэмжих” сангийн гүйцэтгэх захирал С. Эрдэнэбат болон албаны бусад хүмүүс оролцов.



“ШАР ЦАВ” ҮЛЭГ ГҮРВЭЛИЙН МӨРТ ГАЗАРТ ХИЧНЭЭН ТӨРЛИЙН МӨР БАЙДАГ ВЭ



Эрдэмтдийн судалгаагаар 3-4 төрөлд хамаарагдах нийт 20,000 гаруй тооны мөр байдаг.



ТРИДАКТИЛ БУЮУ 3 ХУРУУТ ДАРДАС



Энэ төрлийн мөрнүүд нь Шар Цав олдворт газар түгээмэл ажиглагдана. Эдгээр дардсуудын ерөнхий хэлбэр нь нарийхан, урт, хуруунуудын ялгарал сайн, дунд буюу эрүүл хуруу нь бусдаасаа урт байдаг ажээ. Хурууны хумсны ор мөр нь мөн сайтар ажиглагддаг. Гурван хуруут мөр хэмжээний хувьд хэд хэдэн янз байдаг ба мөр гаргагч амьтдын олноороо явж өнгөрсөн замуудыг ажиглах боломжтой. Эдгээр мөрний хэлбэр болон явж өнгөрсөн зам зэрэгт хийсэн нарийвчилсан судалгааны үр дүнгээр нийт 5 төрлийн үлэг гүрвэл ганцаар болон сүргээрээ явж өнгөрсөнийг тогтоосон байна. Эдгээр мөр гаргагч амьтдын төрөл зүйлүүдэд жижиг биетэй, махчин алварезавр төрлийн үлэг гүрвэлүүд, бага биетэй (залуу) карнозаврууд, жижиг хэмжээтэй Авимимус ордог.



Tridactyl footprints are common at the Shar Tsav site. They are preserved as long, slender, separated digital impressions, as well as the claw marks are preserved. Several along with the associated trackways were identified. Several dinosaur taxa were identified. Even some of them travel includes small bodied carnivorous alvarezosaurs, small Avimimus.

АНКИЛОЗАВР БУЮУ ХУЯГТ ҮЛЭГ ГҮРВЭЛИЙН МӨР



(ARMORED)

Шар Цав орчимд зуйван болон дугариг хэлбэртэй мөр түгээмэл тохиолдоно. Хэдийгээр эдгээр мөрнүүд нь элбэг ч хадгалагд муутай. Эрдэмтэд зарим хагас сар хэлбэрийн дугариг мөрөөс 5 богино хурууны дардсуудыг ажигласан байдаг. Мөн эдгээр мөрний үлдэсэн амьтдын хөл хоорондын зай нь маш өргөн байсан аж. Алхаа хөл хоорондын зай, алхаа хоорондын зай зэрэгт үндэслэн эдгээр мөрнүүдийг гаргасан байж болох амьтан нь анкилозаврууд буюу хуягт үлэг гүрвэлүүд хэмээн тодорхойлжээ. Эдгээр амьтад нь биеэ бүрхсэн олон жижиг ясжиг зузаарсан хуяг маягийн бүрхүүлтэй, сүүднийхээ үзүүрт том хэмжээтэй муна маягийн зүйлтэй. Анкилозаврууд нь өсвөр үедээ сүрэгтэн амьдардаг байсан ба сүрэг нь ойролцоогоор 20 орчим бодьгалаас бүрддэг байжээ.



ҮЛЭГ ГҮРВЭЛИЙН МӨР

Үлэг гүрвэлийн мөр хэрхэн хадгалагдан үлддэг вэ?

Үлэг гүрвэлүүд нь элс, шавар зэрэг зөөлөн хурдас дээр гишгэснээр тэдгээрийн хөлийн мөр нь тухайн чулуулаг дээр тамгалагдан үлддэг. Цаг хугацаа өнгөрөх явцад тэдгээр мөр нь элс болон нарийн ширхэгтэй хайргаар хучигдаж аажмаар хатууран чулууждаг. Ийнхүү олон сая жил хадгалагдсан мөр салхи, бороонд элэгдэн ил гарч ирснийг нь бид блж судалдаг. Чулуужсан мөр нь салхи, бороо, үер зэрэг бусад байгалийн хүчин зүйлсээс хамгааран ихэнх хэсэг нь элэгдэж үгүй болдог ажээ.





Алсыг харах цэг

Байгалийн хэвийг харах цэг

Жижиг махан идэшт үлэг гүрвэлийн сүрэглэн явсан мөр

Авимимусын мөрний байгалийн хэв

Алхсан мөрт газар

Жижиг байгалийн Хэв бүхий хэсэг

8 мөрний зам

Аварга махан идэштийн мөр

Анхны нээлт хийсэн газар

Хос хуруутын зам мөр

Завроподын мөрнүүдийг харах цэг

“Гол илэрц”-ийн хойд хэсэг Авимимус болон, дунд хэмжээтэй махан идэшт үлэг гүрвэлийн мөрнүүд

Олноор гүйсэн мөрт газар

“Гол илэрцийн дунд хэсэг

Эргэлт хийсэн мөрний хэсэг

“Гол илэрцийн урд хэсэг

**ЭРТНИЙ БИЧЭЭС БҮХИЙ
ДУРСГАЛТ ГАЗАР ХҮРДЭТ
АГУЙ**


Төслийн I үе шатанд Хүрдэт агуйн дурсгалт газарт хамгаалалтын хашааг хийж гүйцэтгэсэн бөгөөд агуйн амнаас гадагш дунджаар 3-5 метрийн зайтай хашааг барьж байгуулав.



Төслийн багийн
гишүүдийн төлөөлөл
болох ШУА-ийн Түүх,
археологийн
хүрээлэнгийн гишүүд
Хүрдэт агуйн гадна талд
танилцуулга болон агуйд
хадгалагдаж буй
бичээсийн зарим
орчуулга бүхий тайлбар
самбаруудыг хийж
гүйцэтгэв.



Мөн агуйн дурсгал руу доод талаасаа өгсөж очих боломжтой шат хийсэн бөгөөд явган хүнд учрах эрсдэл, агуйн эргэн тойрон дахь хадны байршлаас шалтгаалж агуйн амнаас агуйн доод ёроол хүртэл нийт 5 м орчим урттай, 2 м орчим өргөнтэй шат хийж гүйцэтгэв.



Төслийн явцын үр дүн

- Төслийг хэрэгжүүлэхээс өмнө хийгдсэн ажлууд

- Шар цав, Хүрдэт агуйн менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлаас өмнө Шар цавын олдворт газарт Оюу-Толгой ХХК-ийн дэмжлэгээр 2013 онд олдворт газрын гол хэсгийг хамгаалж 1280 м хамгаалалтын торон хашааг “Манлайн тариалан ХХК”-аар гүйцэтгүүлж барьж байгуулсан бөгөөд 2013 оны хавар “Танан импекс ХХК”-ийн гүйцэтгэлээр 185 м гүний цэвэр усны худаг гаргуулж, худгийн цахилгаан насос суурилуулах, хүчин чадалд нь тохирсон бага оврын цахилгаан үүсгүүр тавих, ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн. Мөн оны намар 4х3 м –ийн хэмжээтэй худгийн байшин, манаачийн байрыг барьж ашиглалтад оруулсан байна.
- Шар цавын олдворт газарт 2013 оноос эхлэн одоог хүртэл ШУА-ийн Палеонтологи, геологийн хүрээлэнгээс харж хамгаалах, арчлан тордох зорилготой эрдэм шинжилгээний туслах ажилтанг цалинжуулан байнга ажлуулж ирсэн бөгөөд энэ ажилтан мөрт газрыг хамгаалахын зэрэгцээ шинээр бүтээн байгуулсан хашаа, худаг, худгийн байшин, бусад үндсэн хөрөнгийг хамгаалж ирсэн байна.
- Мөрт газрыг улам гүнзгийрүүлэн судалж, дэлхий дахинд хүлээн зөвшөөрүүлэх зорилготой нарийвчилсан судалгаа шинжилгээг 1995 оноос хойш 5 удаа хийж гүйцэтгэсэн бөгөөд хамгийн сүүлд 2015 оны 5, 8-р сард ШУА-ийн Палеонтологи, геологийн хүрээлэнгээс 2 удаа хээрийн судалгааг санхүүжүүлэн зохион байгуулж, нийт 21 байршилд үлэг гүрвэлийн онц сонин мөрт хэсгийг нарийвчлан тогтоож хөтөч, тайлбарлагч нарт зориулсан хөтөлбөр бий болгоход зориулагдсан гарын авлага бэлтгэх ажлыг эхлүүлсэн байна.
- 2016 оны 10 сараас 2017 оны 10 сар хүртэл “Шар цав, Хүрдэт агуйн соёлын өвийн менежментийн төлөвлөгөө” -ний дагуу 1-р үе шатны санхүүжилтийн хүрээнд цаг агаарын хүнд нөхцөлд буюу өвлийн улиралд туслан гүйцэтгэгч компани болон бусад шаардлагатай ажиллах хүчийг бүрдүүлэн Шар цавын үлэг гүрвэлийн мөрт газрыг хамгаалсан барилга, зам жим, гүүр, өндөрлөг хэсэгт тавцан, түүнээс доош буух шат, амралтын сүүдрэвч зэргийг барьж байгуулан хаяг тайлбар, гэрэлтүүлэг зэрэг гадна тохижилтын ажлыг гүйцэтгэх, түүхийн дурсгал газар Хүрдэт агуй орчимд агуйг тойруулан хамгаалалтын хашааг барьж байгуулах, бэхжүүлэх, хаягжуулах зэрэг ажлыг зохион байгуулж, төлөвлөсөн хугацаанд чанартай хийж дуусгасан байна.

ТӨСЛИЙН ЗАРДАЛ

- 28.000.000₮ ОТ
- 10.000.000₮ ОТ
- 18.000.000₮ Танан импекс
- 49.000.000₮ ОТ
- 9.800.000₮ ПГХ
- 369.000.000₮ ГОХДСан

ТОГТМОЛ ЗАРДАЛ

- 6.500.00₮ ПГХ
- 19.600.000₮ ПГХ

Төслийн бүтээн байгуулалт,

ТӨЛӨВЛӨЛТ

- Төслийн II шат буюу 2018-2019 онд ШУА-ийн Палеонтологи, геологийн хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачдын сүүлийн жилүүдэд шинээр олж, тогтоосон үлэг гүрвэлийн аварга том хэлхээ яс, дэлхийд цөөн олдсон аварга өвсөн идэшт үлэг гүрвэлийн мөр зэрэг сонирхолтой олдвор дээр байгалийн лаборатори-музей барьж байгуулах, Говийн зүүн бүс дэх судалгааны лаборатори, хээрийн станц, судлаачид болон жуулчдын саатах амралтын өрөө /lounge/ зэргээс бүрдсэн цогцолбор мэдээллийн төв /visitor center/-ийг барьж байгуулснаар энэ төслийн зорилго цогцоороо биелэгдэх боломж бүрдэх юм.
- Энэхүү хээрийн судалгаа шинжилгээний суурин “ЛАБОРАТОРИ МУЗЕЙН” барилгыг барьж ашиглалтад оруулснаар Өмнөговь аймгийн зүүн бүсийн Ханбогд, Манлай сумдын нутагт байх хожуу Цэрдийн галавын Баянширээгийн настай (85-90 сая жилийн өмнөх) Байшин цав, Хуурай цав, Өрөлбэ худаг, Амтгай, Шар цав, Их Шунхат, Хавиргын зоо зэрэг олдворт газруудыг түшиглэсэн судалгааны томоохон станц бий болж аялал жуулчлалын томоохон төв болж өргөжих юм.



V-Ray Adv 3.20.02 | file: remodelling1.max | frame: 00000 | primitives: 2800212 | render time: 0h 40m 30.8s
V-Ray Adv 3.20.02 | file: remodelling1.max | frame: 00000 | primitives: 2066333 | render time: 0h 12m 3.0s



V-Ray Adv 3.20.02 | file: remodelling1.max | frame: 00000 | primitives: 1616210 | render time: 0h 35m 49.9s

Төслөөс хүлээгдэж буй үр дүн

- Оюутолгой компанийн дэмжлэгтэйгээр төслийг хэрэгжүүлснээр 2019 онд Монгол улсад зохиогдох Азийн Үлэг гүрвэлийн холбоо /Asian Dinosaur Association/-ны олон улсын чуулга уулзалт, хурал, хээрийн экскурсийг Шар цав, Хүрдэт агуйн дурсгалт газрыг түшиглэн зохион байгуулах, үзүүлэх, сурталчилах боломж нээгдэнэ.
- Үлэг гүрвэлийн мөрт газрын хадгалалт, хамгаалалт сайжирч, судалгаа шинжилгээ, сурталчилгааны байнгын ажиллагаатай хээрийн нөхцөл дэх палеопарк бий болно.
- Өмнөговь аймгийн зүүн хэсгийн аялал жуулчлалын хөгжлийн нэгэн түшиц газар бий болж, хил орчмын аялал жуулчлал хөгжүүлэхэд орон нутгийн иргэдийн оролцоо нэмэгдэх, шинэ маршрут бий болох үндэс суурь нь болох юм.
- Сум орон нутаг, иргэд аж ахуй нэгж байгууллагад орох орлогын хэмжээ нэмэгдэж орон нутгийн иргэдийн санал санаачлагын хүрээнд цогц аялал зохион байгуулах бүрэн боломж нээгдэх юм.
- Монгол улсын түүх, соёл, байгалийн дурсгал дээр түшиглэсэн аялал жуулчлалын каластрыг Өмнөговь аймгийн зүүн бүсэд бий болгон хөгжүүлснээр манай улсын хөгжлийн хамгийн ирээдүйтэй салбарын нэг аялал жуулчлалаас энэ бүс нутгийн иргэд үр шимийг нь хүртэх боломж нээгдэх юм.
- Шар цавын олдворт газар нь улсын хамгаалалтад байх “Палеонтологийн дурсгалт газар” тул Монгол улсын засгийн газрын тогтоолоор баталсан хамгаалалтын бүсийн гадна талын төлөвлөгдсөн газарт орон нутгийн иргэд, хувийн хэвшлийнхний оролцоотой жуулчны бааз, үйлчилгээний газруудыг байгуулах нь нээлттэй бөгөөд ирээдүйд энэ нутаг амралт зугаалга, аялал жуулчлалын томоохон бүс болно.
- 2018 онд ЮНЕСКО-ийн Монгол улсад зохиогдох олон улсын чуулга уулзалт, хурал, хээрийн экскурсийг Шар цав, Хүрдэт агуйн дурсгалт газрыг түшиглэн зохион байгуулах, үзүүлэх, сурталчилах боломж нээгдэж. Дэлхийн байгалийн өвд бүртгүүлэх шат ахих юм.

**АНХААРЛ ТАВЬСАН ТА
БҮХЭНД**



БАЯРЛАЛАА